



Орхон аймаг дахь төрийн
аудитын газар

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ | 2023 ОН
ТАЙЛАН



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	1
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	2
ХОЁРДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН АУДИТ	12
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ	16
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙЦЛИЙН АУДИТ.....	18
ТАВДУГААР БҮЛЭГ. ИТХ-ЫН ХҮСЭЛТЭЭР БОЛОН ӨӨРСДИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТ.....	20
ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ДОТООД АЖИЛ.....	21
ДОЛООДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	29
НАЙМДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, САНАЛ.....	30



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
ББНШК	Баримт бичиг нягтлан шалгах комисс
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗХЭЗГ	Захиргаа, хууль, эрх зүйн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУИС	Монгол Улсын их сургууль
МТТ	Мэдээлэл технологийн төв
НТАГ	Нийслэл дэх төрийн аудитын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАГ	Төрийн аудитын газар
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТАНЦС	Төрийн албаны нэгдсэн цалингийн систем
ТБОНӨДААН	Төрийн болон орон нутгийн өмчийт аж ахуйн нэгж
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчийт үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАК	Хувийн аудитын компани
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ДАХШҮГ	Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газар



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан

Орхон аймаг дахь Төрийн аудитын газар нь Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах” зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн, хэрэгжилтийг бүрэн хангуйж ажиллаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/235 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулж тайлагнах журам”-ын дагуу байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайлан мэдээг нэгтгэн, дүгнэж энэхүү тайланг бичлээ.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дэвшүүлсэн зорилтын биелэлт

Төрийн аудитын байгууллага 2023 оныг “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах” жил болгон зарласантай уялдуулан 7 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг тайлагнан ажиллаа. Үүнд:

1. ТАБ-ын 2023 оны зорилтыг хангах ажлын дэд төлөвлөгөөг боловсруулан баталж, Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газарт хүргүүлж, teamсд байршуулсан.
2. Төрийн аудитын газраас 2019-2022 онд гүйцэтгэсэн гүйцэтгэл, нийцэл, Төрийн болон орон нутгийн өмчтэй компанийн санхүүгийн тайлангийн аудитын шийдвэр, судалгааг гаргаж нэгтгэн 2023 оны 04 сарын 10-ны өдөр Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газарт хүргүүлсэн. Мөн 2020-2022 онуудад хийсэн аудитын дата мэдээллийг ирүүлсэн маягтын дагуу гаргаж, 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газарт хүргүүлсэн. 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар завсрлын үеийн аудитад 66 байгууллагыг хамруулан, 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, тухайн байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зөвлөмж, зөвлөгөөг хүргүүлэн ажиллаа.
3. “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр нөлөөг тооцох цогц бодлого, горим бий болгохтой холбоотой тулгамдсан асуудлын талаар санал хүргүүлэх” ажлын хүрээнд албан хаагчдын дунд аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр нөлөөг сайжруулах хэлэлцүүлгийг 2023 оны 06 сарын 28-ны зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгээс гарсан саналыг нэгтгэвэл:

- Төлбөрийн актыг биелүүлж ажиллаагүй бол Төрийн аудитын тухай хуулийн 42.1-д заасны дагуу хариуцлага тооцуулах албан шаардлагыг дээд шатны удирдлагад хүргүүлж, хариуцлага тооцуулах зохицуулалттай боловч тухайн акт нь биелэгдэхгүй хэвээр үлдэж байна. Энэ тохиолдолд цааш нь хэрхэн шийдвэрлэх зохицуулалтыг тодорхой болгох. Тухайлбал Захиргааны ерөнхий хуулийн 84.1-д “Захиргааны шийдвэрийг дараах байгууллага гүйцэтгэнэ:”, 84.1.1-д “захиргааны актыг батлан гаргасан захиргааны байгууллага” гэж заасан боловч манай ТАБ-д энэ хүрээнд ЗЕХ-н 86.1.3-д заасан албадан гүйцэтгэх арга хэмжээ авах зохицуулалт тодорхойгүй байна. /Тодорхой болгох/



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан

- ТАБ-ЫН ЗҮГЭЭС ГАРГАЖ БУЙ ЗАХИРГААНЫ АКТУУДЫГ ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД ЗААСАНЧЛАН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТАРЧ БИЕЛЭЛТ ТООЦДОГ ТАЛААР ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ БОЛОХ. /Аудиторуудад улсын байцаагчийн эрх олгох/
- БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХ ЗАМААР ТАБ-ААС ГАРСАН ЗАХИРГААНЫ АКТУУДЫН БИЕЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ.
- ШИЙДВЭР ГАРГАХДАА БИЕЛЭЛТ ТООЦОХ ХУГАЦААГ ЗӨВ ТООЦОЖ БАЙХ.
- АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ БАЙГУУЛЛАГА ДЭЭР ОЧИЖ БИЕЛЭЛТИЙГ ХАНГУУЛАХ.
- БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА БОЛОН НЯГТЛАН БОДОГХ НАРТ ТӨРИЙН АУДИТЫН ЗҮГЭЭС ӨГЧ БУЙ ЗӨВЛӨМЖ, АЛБАН ШААРДЛАГА, АКТЫН ТАЛААР СУРГАЛТ СЕМИНАР ХИЙЖ, БИЕЛЭЛТИЙГ ХЭРХЭН БҮРДҮҮЛЭХ ТАЛААР АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨГ ЖИЛД 1-2 УДАА ӨГДӨГ БАЙХ.
- ТУХАЙН ЖИЛ ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, АЛБАН ШААРДЛАГА, ТӨЛБӨРИЙН АКТАД ЖИЛ БҮР ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, САЙЖРУУЛАХ АРГА ЗАМЫГ ТОДОРХОЙЛЖ БАЙХ.
- АЛБАН ХААГЧДЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ТАЛААРХ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ.
- ОЛОН НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ХӨНДСӨН СЭДВЭЭР АУДИТ ХИЙЖ, АУДИТЫН ТАЙЛАНГ ЦАГ АЛДАХГҮЙ МЭДЭЭЛЖ БАЙХ.
- АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙГ ХЭДЭН ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙХАД БИЕЛЭЛТИЙГ ТООЦОХ ТАЛААР ТОДОРХОЙ ЗОХИЦУУЛАЛТТАЙ БОЛОХ.



ТУХАЙН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН ҮР ДҮНГ НЭГТГЭН, АНУЗГ-Т 2023 ОНЫ 06 САРЫН 29-НЫ ӨДӨР ХҮРГҮҮЛСЭН.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан

4. Байгууллагын хэмжээнд З-аас дээш жилээр хугацаа хэтэрсэн аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй судалгаа гаргаж, АНУЗГ-т хүргүүлсэн.
5. Хугацаа хэтэрсэн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжээгүй шалтгаан нөхцөлийг тодруулан, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч ажиллаа.
ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүн, аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцууллаа.



Аймгийн Засаг даргатай зөвшилцөн бүх төсөв захирагч нарыг 2 сум, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, нутгийн захиргааны байгууллагаар нь ангилан, аудитаар илэрсэн зөрчил, цаашид анхаарах асуудал, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулах талаар сургалт хэлэлцүүлгийг 6, 11-р саруудад зохион байгуулсан.



Эрүүл мэндийн салбарын байгууллагуудын удирдлага, нягтлан бодогчдод аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал, тэдгээрийн шалтгаан нөхцөлийг танилцуулж, цаашид анхаарах зүйл болон биелэлтийг хэрхэн хангаж, давтан гаргахгүй ажиллах талаар сургалт зохион байгуулсан.

Боловсролын салбарын байгууллагуудын удирдлага, нягтлан бодогчдод аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал, тэдгээрийн шалтгаан нөхцөлийг танилцуулж, цаашид анхаарах зүйл болон биелэлтийг хэрхэн хангаж, давтан гаргахгүй ажиллах талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан



Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас Орхон аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ-ын санхүүгийн алба, нягтлан бодогчид, ЗДТГ-ын албан хаагчдад 2023 оны 06 сарын 22-ны өдөр 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар болон Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, аудитын шийдвэрийн хэрэгжилтийн талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Орхон аймгийн Жаргалант сумын төсвийн байгууллагуудын удирдлага, санхүүгийн ажилтнууд, ЗДТГ-ын албан хаагчдад 2023 оны 06 сарын 21-ны өдөр 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар болон Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, аудитын шийдвэрийн хэрэгжилтийн талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа.



Орхон аймгийн Соёл, урлагийн салбарын байгууллагуудын удирдлага, нягтлан бодогчдод 2023 оны 06 сарын 23-ны өдөр 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар болон Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, аудитын шийдвэрийн хэрэгжилтийн талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Сургалт, хэлэлцүүлгийн төгсгөлд төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуултад хариулт өгч, санал солилцлоо.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан



Орхон аймгийн Эрүүл мэндийн салбарын байгууллагуудын удирдлага, нягтлан бодогчидтой 2023 оны 11 сарын 30-ны өдөр, Соёл, урлагийн салбарын байгууллагуудын нягтлан бодогчидтой 2023 оны 11 сарын 28-ны өдөр уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Тус уулзалт, хэлэлцүүлгээр өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг хэрхэн хангаж ажилласан эсэх, биелэлтийг цахим системд хэрхэн оруулах, түүнийг хэрхэн үнэлэх, 2023 оны санхүүгийн тайлангийн завсрлын аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлыг жилийн эцсийн санхүүгийн тайландаа хэрхэн засаж, запруулах, тайлан бэлтгэхтэй холбоотой болон тус асуудлыг хэрхэн үнэлж, шийдвэрлэх талаар ярилцлаа. Хэлэлцүүлгийн төгсгөлд төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуултад хариулт өгч, санал солилцлоо.




Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас орон нутгийн төсвийн байгууллага, ОНӨҮГ-н нягтлан бодогчид болон ТЕЗ-ийн ерөнхий нягтлан бодогчтой 2023 оны 11 сарын 29-ны өдөр уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Тус уулзалт, хэлэлцүүлгээр өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг хэрхэн хангаж ажилласан эсэх, биелэлтийг цахим системд хэрхэн оруулах, түүнийг хэрхэн үнэлэх, 2023 оны санхүүгийн тайлангийн завсрлын аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлыг жилийн эцсийн санхүүгийн тайландаа хэрхэн засаж, запруулах, тайлан бэлтгэхтэй холбоотой болон тус асуудлыг хэрхэн үнэлж, шийдвэрлэх талаар ярилцлаа. Хэлэлцүүлгийн төгсгөлд төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуултад хариулт өгч, санал солилцсон.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан

6. 2023 онд гүйцэтгэсэн СТА-н 100 төсөв захирагчийн хураангуй тайланг Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд, гүйцэтгэл, нийцлийн б аудитын тайланг бэлтгэн гаргаж, Төрийн аудитын байгууллагын цахим хуудас open.audit.mn сайтад байршуулсан.

2023 онд гүйцэтгэсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмжийн биелэлт, үр дүнгийн талаар байгууллагын цахим хуудас, open.audit.mn болон бусад мэдээллийн урсгалаар дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлсэн.



Тэргүүлэх аудитор Ц.Нармандах Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, гүйцэтгэсэн аудитуудтай холбоотой 2023 онд 4 удаа ярилцлага өгсөн.



Аудитын менежер Б.Буян-Ундрах, ахлах аудитор Г.Оргилмерэн нар орон нутгийн TV10 телевизийн "Өдрийн зочин" нэвтрүүлэгт оролцож, Төрийн аудитын талаар ойлголт болон аудитын сэдэв сонгох ажиллагааны талаар ярилцлага өгсөн.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан



Ахлах аудитор В.Жавзмаа Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудит, ахлах аудитор Т.Болормаа "Хөдөө аж ахуйн салбарын зээл тусlamжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж" гүйцэтгэлийн аудитын талаар Erdenet.mn сайтад ярилцлага өглөө.



Байгууллагын цахим хуудсаар дамжуулан ахлах аудитор Г.Оргилмөрөн "Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө" гүйцэтгэлийн аудит, аудитор Б.Бямбатогтох "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын видео танилцуулга хийж, олон нийтэд түгээлээ.

Аудитын үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сум, багийн төвлөрсөн байрууд, иргэд олон нийт ихээр төвлөрдөг томоохон худалдааны төвүүдэд төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулж, үзүүлэн таниулах материал тарааж, иргэдэд мэдээлэл хүргэсэн.





Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан


Иргэд, олон нийт ихээр төвлөрдөг гудамж, талбайд 2023 оны 06 сарын 20-оос 22-ны өдрүүдэд Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулж, үзүүлэн таниулах материал тарааж, иргэдэд мэдээлэл хүргэн, санал хүсэлтийг сонсож ажиллаа.



“Зэс фестиваль” арга хэмжээний үеэр Амарын талбайд 2023 оны 09 сарын 22-оос 23-ны өдрүүдэд Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулж, үзүүлэн таниулах материал тарааж, иргэдэд мэдээлэл хүргэн, санал хүсэлтийг сонсож ажиллаа.



Аудитын тайлан, үр дүнгээр хийсэн үзүүлэн таниулах материал



2020-2022 онд хийж гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар товч танилцуулга бэлтгэн иргэд, олон нийтэд түгээсэн.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан



Тайлант хугацаанд нэгдсэн удирдамжаар "Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн", "Эрүүл мэндийн даатгал, үр дүнд сууринласан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө", "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт", "Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж", "Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт" нийтдээ 5 гүйцэтгэл, нийцлийн аудитуудын инфографик бэлтгэн олон нийтэд түгээсэн.

Завсрын үеийн аудитад шалгагдагч байгууллагын жагсаалтыг 2023 оны 09 сарын 04-ний өдрийн А/188 дугаар тушаалаар баталгаажуулж, 2023 оны 09 сарын 04-ний өдрөөс 2023 оны 11 сарын 27-ны хооронд 66 байгууллага дээр очиж ажилласан. Завсрын аудит хийх явцдаа өмнөх аудитаар шалгагдагч байгууллагуудад өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангулан ажиллаа. Фас системийн "Санхүүгийн аудитын системийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт оруулах" цэсээр шийдвэрийг хэрэгжилтийг хянаж, үнэлгээ өгч, шийдвэрийн хэрэгжилтийг stat.audit.mn цахим системээр хангулан ажилласан.

7. Төрийн аудитын байгууллагын 2023 оны зорилтыг хангах ажлын дэд төлөвлөгөөний 2023 оны 2, 3, 4 дүгээр улирлын биелэлтийн тайланг 2023 оны 06 сарын 30, 10 сарын 03, 12 сарын 01-ны өдрүүдэд Teamsd байршуулсан.

Орон тоо, бүтэц зохион байгуулалт

Орхон аймаг дахь Төрийн аудитын газар нь дарга, тэргүүлэх аудитор 1, аудитын менежер 1, ахлах аудитор 3, аудитор 8, жолооч 1, нийт 13 албан хаагчтайгаар Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан зохион байгуулалтын бүтэц, үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, орон тоо, албан тушаалын жагсаалтын хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан



Тайлант хугацаанд хүүхэд асрах чөлөөтэй ажилтнуудын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байсан О.Хэрлэнзаяа, Ж.Цэнгэлмаа нарын хөдөлмөрийн харилцааг аудитор О.Гантуяа, Т.Болормаа нарын хүсэлтийг үндэслэн МУЕА-ын шийдвэрээр дуусгавар болгосон.

Зэрэг дэв олгуулах 3 албан хаагчийн мэдээллийг ЯАГ-т хүргүүлсэн. Төрийн албаны хүний нөөцийн цахим системд албан хаагчдын мэдээллийг бүрэн мэдээлж, ТАЗ-ийн Орхон аймаг дахь салбар зөвлөлд хүний нөөцийн тайлан, судалгааг тухай бүр хүргүүлэн ажиллаа.

Нийт албан хаагчдын 91 хувь нь эдийн засагч, нягтлан бодогчийн мэргэжилтэй бөгөөд 8 мэргэшсэн нягтлан бодогч, магистр 9, эрх зүйч мэргэжилтэй 1 албан хаагч ажиллаж байна.

Төрийн аудитын байгууллагад ажилласан жилээр авч үзвэл нийт албан хаагчдын 50.0 хувь нь 5 хүртэл жил, 33.4 хувь нь 6-10 жил, 8.3 хувь 11-15 жил, 8.3 хувь нь 15-аас дээш жил тогтвортой, суурьшилтай ажиллаж байна. Насны бүлгээр авч үзвэл 50.0 хувь нь 31-40 нас, 33.3 хувь нь 41-50 хүртэл нас, 16.7 хувь нь 51-ээс дээш насны албан хаагчид байна. Нийт албан хаагчдын 41.7 хувь буюу 5 эрэгтэй, 58.3 хувь буюу 7 эмэгтэй албан хаагч эзэлж байна. Төрийн аудитын байгууллагад ажилласан жилээр авч үзвэл нийт албан хаагчдын 50.0 хувь нь 5 хүртэл жил, 33.4 хувь нь 6-10 жил, 8.3 хувь 11-15 жил, 8.3 хувь нь 15-аас дээш жил тогтвортой, суурьшилтай ажиллаж байна.

Байгууллагын бүтэц, орон тоо, ажлын ачаалалд үндэслэн аудитыг хуваарилан, жигд тэнцвэртэй байх бодлого барин ажилласнаар ажлын чанарт зэрэг нөлөө үзүүлж, төлөвлөгөөт аудит, ЯАГ-аас ирсэн үүрэг даалгавруудыг цаг хугацаандаа хэрэгжүүлэн ажилласан.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан

Нийт аудитын тоо, илрүүлсэн алдаа зөрчил



Санхүүгийн тайлангийн аудитад 135 байгууллага хамруулсан бол гүйцэтгэлийн 3 аудит, нийцлийн 3 аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн.



Энэ онд нийт 25,189.1 сая төгрөгийн 654 алдаа, зөрчил илрүүлж, 664.2 сая төгрөгийн зөрчилд 147 төлбөрийн акт тогтоож, 18,819.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 133 албан шаардлага, 3,464.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 310 зөвлөмж өгч, 5 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 2,240.9 сая төгрөгийн 59 алдааг залруулсан.

Тайлант онд нийтдээ 9,879.6 сая төгрөгийн 168 санхүүгийн, 1 санхүүгийн бус үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлсэн байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН АУДИТ

Орхон аймаг дахь Төрийн аудитын газар нь 135 төсөв захирагч, байгууллага, аж ахуйн нэгжид Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаварт хугацаанд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2022-2023 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл”, “Төрийн аудитын байгууллагаас төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх аргачилсан зөвлөмж”-ийг мөрдөн 120 төсвийн шууд захирагч, Засгийн газрын 2 сан, 1 төвлөрүүлэн захирагч, 1 төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн болон орон нутгийн өмчит 11 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийлээ. 2022 оны санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээ тайланг гаргаж, УАГ-т 2023 оны 07 дугаар сарын 04-нд хүргүүлж ажиллаа.

Аудитыг Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд АДБОУС, ТАБ-ын Аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитын заавар аргачлалын хүрээнд, аудитын үе шат бүрд санхүүгийн тайлангийн аудитын FAS систем ашиглан гүйцэтгэлээ.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан



Орхон аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан цаглаварт хугацаанд гүйцэтгэж, "зөрчилгүй" санал дүгнэлт өгч, аудитын тайланг баталгаажууллаа. Аудитад 1 аудитор, хянан удирдах ажилтнууд оролцож, нийт 10 өдөр зарцуулан, 30 цаг илүү ажилласан байна.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайландаа сумын ТТЗ-ийн 1, төсвийн шууд захирагчдын 33, орон нутгийн өмчтэй хуулийн этгээдийн 7, нийт 41 санхүүгийн тайлан нэгтгэнээс 23 байгууллагад дүгнэлт гаргаж, 18 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Аудитын тайлан, зөвлөмжийг Орхон аймгийн Засаг даргад 2023 оны 04 дүгээр сарын 25-нд хүргүүлсэн. Аудитаар нийт 3,113.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 7.5 сая төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 2,498.0 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, үйл ажиллагааг сайжруулахаар 607.8 сая төгрөгийн 7 зөвлөмж өгсөн.

2023 оны 12 сарын 01-ны байдлаар 4 зөвлөмж бүрэн хэрэгжиж, 607.8 сая төгрөгийн 3 зөвлөмж, 2,498.0 сая төгрөгийн албан шаардлагын биелэлт тооцох хугацаа болоогүй, хэрэгжих шатандаа байна.

Санхүүгийн тайлангийн аудитын 71.9 хувь буюу 97 төсөв захирагчийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллага, 28.1 хувь буюу 38 санхүүгийн тайланг Далай ван аудит ХХК, Мөнгө нөөц баялаг аудит ХХК гэрээгээр гүйцэтгэсэн. Тайлант хугацаанд 102 бие даасан санал дүгнэлт гаргаж, 33 тайланг түүвэрт хамрууллаа.

Санал дүгнэлтийн 93.2 хувь буюу 95 тайландаа "зөрчилгүй", 5.9 хувь буюу 6 тайландаа "хязгаарлалттай", 0.9 хувь буюу 1 тайландаа "сөрөг", 0.9 хувь буюу 1 тайландаа санал дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.



Орхон аймгийн Засаг даргын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан цаглаварт хугацаанд Орхон аймгийн Засаг даргын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудитыг хийж, тайланг аймгийн ИТХ, Засаг дарга болон ҮАГ-т хүргүүллээ.

Аудитаар үйл ажиллагаа, үр дүнг сайжруулах З зөвлөмжийг хүргүүлсэн.

Аудитад 1 аудитор, хянан удирдах ажилтнууд оролцож, 10 өдөр зарцуулсан.

Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасан цаглаварт хугацаанд Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, “зөрчилгүй” санал дүгнэлтийг хүргүүлсэн.

Аудитаар нийт 19.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж З зөвлөмж хүргүүлсэн байна. Тухайн З зөвлөмж 2023 оны 12 сарын 01-ны байдлаар бүрэн биелсэн байна.

Аудитад 1 аудитор, хянан удирдах ажилтнууд оролцож, нийт 6 өдөр зарцуулан, 18 цаг илүү ажилласан байна.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглаварт хугацаанд 120 төсвийн шууд захирагчдын тайланг аудитад хамрууллаа. Үүнээс 89 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 31 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж гүйцэтгэлээ. Санал дүгнэлт гаргасан 89 байгууллагын 84 байгууллагад “зөрчилгүй”, 5 байгууллагад “хязгаарлалттай” санал дүгнэлт өгч, тайланг баталгаажуулсан.

Аудитыг ТАГ-ын 10 аудитор, 2 аудитын хуулийн этгээд гүйцэтгэж, аудитын менежер болон тэргүүлэх аудитор хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 4,383.8 сая төгрөгийн 499 алдаа, зөрчил илрүүлснээс 630.8 сая төгрөгийн 50 алдааг залруулж, 101.7 сая төгрөгийн зөрчилд 116 төлбөрийн акт тогтоож, 2,347.1 сая төгрөгийн зөрчилд 104 албан шаардлага, 1,304.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 228 зөвлөмж өглөө.

Аудитаар тайлант онд хүргүүлсэн 101.7 сая төгрөгийн 116 төлбөрийн акт, 2,347.1 сая төгрөгийн 104 албан шаардлага бүрэн хэрэгжсэн байна. Тайлант онд өгсөн 1,292.7 сая төгрөгийн 227 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаа.

ТБОНӨААН-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглаварт хугацаанд, ТБОНӨААН-ийн санхүүгийн тайлангийн аудитад 10 ААН-ийг хамруулж, 8 тайланд “зөрчилгүй”, 1 аж ахуйн нэгжид “хязгаарлалттай”, 1 аж ахуйн нэгжид “сөрөг” санал дүгнэлт өгч ажиллалаа.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан

Төрийн болон орон нутгийн өмчтэй байгууллагуудын санхүүгийн аудитыг ХАК-ын 2, ТАГ-ын 8 аудитор гүйцэтгэж, аудитын менежер, тэргүүлэх аудитор хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 8,646.7 сая төгрөгийн 84 алдаа, зөрчил илрүүлснээс 61.3 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 56.5 сая төгрөгийн зөрчилд 19 төлбөрийн акт тогтоож, 8,224.7 сая төгрөгийн зөрчилд 21 албан шаардлага, сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлага, 304.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 37 зөвлөмж өглөө.

Тайлант онд хүргүүлсэн 48.4 сая төгрөгийн 18 төлбөрийн акт, 8,224.7 сая төгрөгийн 21 албан шаардлага, 304.3 сая төгрөгийн 36 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаа.

Засгийн газрын тусгай сангийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглаварт хугацаанд, ЗГТС-ийн санхүүгийн тайлангийн аудитаар 1 сангийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 1 санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн бөгөөд 1 санд “зөрчилгүй” санал дүгнэлт өгч баталгаажууллаа.

ЗГТС-ын санхүүгийн аудитыг ТАГ-ын 2 аудитор гүйцэтгэж, аудитын менежер, тэргүүлэх аудитор хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 241.6 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илрүүлснээс 208.0 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 0.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага, 33.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Тайлант хугацаанд дээрх шийдвэрийн хэрэгжилт бүрэн хангагдсан.

Санхүүгийн аудитын дүн: Аудитад хамрагдсан байгууллагуудад төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, гарсан алдаа зөрчлүүдийг арилгах, зөвлөмж, албан шаардлагыг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулснаар, үндсэн хөрөнгийн бүртгэл тооцоог үнэн зөв хийж, бүртгэл тайланд тусгасан, хадгалалт хамгаалалтыг сайжруулж хөрөнгө эзэнгүйдэх, нягтлан бодох бүртгэл, тайлагнан сайжирч, арвилан хэмнэлт, үр нөлөө, үр ашигтай төсвийг зарцуулах, төсвийн хөрөнгийн зарцуулалтыг үр дүнгүй, үр ашиггүй зарцуулагдах эрсдэлээс сэргийлсэн үр дүн, үр өгөөжийг бий болголоо.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 135 санхүүгийн тайлангийн аудитыг холбогдох хууль, журам, стандартын дагуу, төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэж, аудитад хамрагдсан байгууллагуудаар 2023 оны 12 сарын 01-ны байдлаар 257.6 сая төгрөгийн 148 санхүүгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлсэн.

Аудитад ахлах аудитор 3, аудитор 7, 2 ХАК оролцон, аудитын менежер, тэргүүлэх аудитор хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, 610 хүн/өдөр, зарцуулж ажиллалаа.

Аудитаар нийт 16,405.1 сая төгрөгийн 602 алдаа, зөрчил илрүүлснээс 907.5 сая төгрөгийн 58 алдааг залруулж, 158.4 сая төгрөгийн зөрчилд 136 төлбөрийн акт тогтоож, 13,069.8 сая төгрөгийн зөрчилд 127 албан шаардлага, 2,269.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 279 зөвлөмж өглөө.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан

Тайлант онд тогтоосон төлбөрийн актын 94.9 хувь, албан шаардлагын 80.9 хувь, зөвлөмжийн 72.7 хувийн хэрэгжилтийг хангулан ажиллаа.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

ТАБ-ын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ЯАГ-ын нэгдсэн удирдамжаар 3 аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
2. Эрүүл мэндийн даатгал, үр дүнд сууринсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө
3. Хөдөө аж ахуйн салбарын зээл тусlamжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж

Гүйцэтгэлийн аудитуудыг төлөвлөсөн хугацаанд хийж, аудитын тайлан, төлбөрийн акт, албан шаардлагыг ЯАГ, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 6,291.1 сая төгрөгийн 33 зөрчил илрүүлж, тэдгээрийн 503.5 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 5,761.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 16 зөвлөмж, 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 142 хүн/өдөр зарцуулсан байна.

Төлбөрийн акт: Тайлант оны эхэнд 113.9 сая төгрөгийн 5 төлбөрийн актын эхний үлдэгдэлтэй байсан бол 503.5 сая төгрөгийн 10 төлбөрийн акт нэмж бүртгэгдэн, нийт 499.0 сая төгрөгийн 12 төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 118.4 сая төгрөгийн 3 төлбөрийн актын эцсийн үлдэгдэлтэй байна.

Албан шаардлага: Тайлант оны эхэнд 1,090.7 сая төгрөгийн 6 албан шаардлагын үлдэгдэлтэй байсан бол 5,761.8 сая төгрөгийн 5 албан шаардлага нэмж бүртгэгдсэн. 2023 оны 12 сарын 01-ны байдлаар 6,274.5 сая төгрөгийн 9 албан шаардлагын биелэлт хангагдсан байна.

Зөвлөмжийн хэрэгжилт: Тайлант онд 9,758.4 сая төгрөгийн 48 зөвлөмж хэрэгжиж, 20.8 сая төгрөгийн 2 зөвлөмжийн үлдэгдэлтэй байна.

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

"Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын хөтөлбөр болон аудитын үр өгөөжийн урьдчилсан төлөвлөлтийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөр баталж, аудитын нээлтийг 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хийсэн.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан




Аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэж, аудитын тайланг 2023 оны 05 сарын 02-ны өдрийн A/08 дугаар тушаалаар баталгаажуулсан, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад хүргүүлсэн.

Аудитын тайландаа тусгагдсан зөвлөмжийг холбогдох байгууллагуудад албан бичгээр хүргүүлж ажиллаа.

Аудитаар нийт 6,187.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 437.7 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 5,749.3 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, хөрөнгө оруулалтын үр дүнг сайжруулах 6 зөвлөмж хүргүүлсэн. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй 3 албан хаагчид сахилгын харицлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн

Эрүүл мэндийн даатгал, үр дунд сууринласан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө

“Эрүүл мэндийн даатгал, үр дунд сууринласан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийг 2023 оны 03 сарын 15-нд баталж, аудитын нээлтийг 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан.




Аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэж, аудитын тайланг 2023 оны 05 сарын 19-ний өдрийн A/09 дүгээр тушаалаар баталгаажуулсан, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар, аймгийн Засаг дарга, Орхон аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Орхон аймгийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн. Аудитаар 65.9 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааг сайжруулах 5 зөвлөмжийг хүргүүлсэн.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан

Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусlamжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж

“Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусlamжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийг 2023 оны 05 сарын 26-нд баталж, аудитын нээлтийг 2023 оны 06 сарын 02-ны өдөр зохион байгуулсан.



Хэрэгжүүлээгүй 1 аж ахуйн нэгжийн зээлийн үлдэгдэл төлбөр 1,333.3 сая төгрөгийг бүрэн барагдуулж үр өгөөжөөр бүртгэсэн.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙЦЛИЙН АУДИТ

ТАБЫН 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 3 аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт
2. Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудит

НИЙЦЛИЙН АУДИТУУДЫГ ТӨЛӨВЛӨСӨН ХУГАЦААНД ХИЙЖ, АУДИТЫН ТАЙЛАН, ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГЫГ ҮАГ, ХОЛБОГОХ БАЙГУУЛЛАГУУДАД ХҮРГҮҮЛСЭН.

НИЙЦЛИЙН АУДИТААР НИЙТ 1,172.1 САЯ ТӨГРӨГИЙН 14 ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛЖ, ТЭДГЭЭРИЙН 2.4 САЯ ТӨГРӨГИЙН ЗӨРЧИЛД 1 ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООЖ, ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ 1 АЛБАН ШААРДЛАГА, ДАВТАН ГАРГАХГҮЙ БАЙХ 9 ЗӨВЛӨМЖ ӨГЧ, 130 ХҮН/ӨДӨР ЗАРЦУУЛСАН БАЙНА.

ТӨЛБӨРИЙН АКТ: Тайлант оны эхэнд 22.8 сая төгрөгийн 1 төлбөрийн актын эхний үлдэгдэлтэй байсан бол 2.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт нэмж бүртгэгдэн,

Аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэж, аудитын тайланг 2023 оны 08 сарын 18-ны өдрийн A/12 дугаар тушаалаар баталгаажуулан, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Орхон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

Аудитын тайланда тусгагдсан зөвлөмжийг холбогдох байгууллагуудад албан бичгээр хүргүүлж ажиллаа.

Аудитаар нийт 38.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 12.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, хөрөнгө бүртгэх 25.9 сая төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитын явцад төслийг



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан

НИЙТ 15.0 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдаж, 10.2 сая төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй болсон.

Албан шаардлага: Тайлант оны 1 албан шаардлага нэмж бүртгэгдэн, биелэлт тооцох хугацаа болоогүй байна.

Зөвлөмжийн хэрэгжилт: Тайлант онд 1,169.7 сая төгрөгийн 12 зөвлөмжийн үлдэгдэлтэй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт

"Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт" нийцлийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр болон аудитын үр өгөөжийн урьдчилсан төлөвлөлтийг 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр баталж, аудитын нээлтийг 2023 оны 05 дугаар сарын 26-нд өдөр хийсэн.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад:

Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохицой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний төсвийг хууль, журамд нийцүүлэн баталж, биелэлтэд хяналт тавьж, үр дүн, хэрэгжилтийг тооцож байх.

Аймгийн Засаг даргад:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийг үндэслэлтэй төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч, дотоод хяналтыг сайжруулах.
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх зардлын төвлөвлөлт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилт олгох явцад байгаль орчны байгууллагын оролцоог хангуулах.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт:

Ойн нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэлэлцэж, үр дүн, хэрэгжилтийг жил бүр хээлцэн дүгнэж байх.

Баян-Өндер, Жаргалант сумын Засаг дарга нарт:

- Байгаль хамгаалагч нарын ажлыг сайжруулж, ажлын гүйцэтгэлийг хянаж, хариуцлагыг сайжруулах.
- Байгалийн нөөцийн ашиглалт дүгнэлт, зөвшөөрөл, гэрээг хууль, журамд нийцүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллах.
- Байгаль орчны мэдээллийн цахим сангийн мэдээллийг үнэн зөв, журамд заасан хугацаанд тайлагнах.

Байгаль орчин, аялалжуулчлалын газарт:

- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлж, үр дүнг наягтэж байх.
- Хүн амын унд, ахуйн болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйдвэрлэл, үйлчилгээ зориулалтаар ус ашиглуулалт дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ байгуулаагүй 23 ашиглагчийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж, хууль журамд нийцүүлж, биелэлтийг нэгтгэж ирүүлэх.

Аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэж, аудитын тайланг 2023 оны 06 сарын 20-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталгаажуулан, Үндэсний аудитын газар, Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, 2 сумын Засаг дарга, БОАЖГ-т хүргүүлсэн. Аудитын тайланда тусгасан зөвлөмжийг 2 байгууллагад албан бичгээр хүргүүлж ажиллаа. Аудитаар нийт 1,172.0 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 2.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоон, нөхөн төлбөрийг тооцож төлүүлэх 1 албан шаардлага хүргүүлж, үйл ажиллагааг сайжруулахаар 1,169.7 сая төгрөгийн 9 зөвлөмжийг хүргүүллээ.

Төлбөрийн актын биелэлт: Төрийн аудитын байгууллагаас 2023 оныг шийдвэрийн хэрэгжилтийн жил болгож зарласантай холбогдуулан өмнөх онуудад үлдэгдэлтэй байсан 2017-2019 оны газрын тухай хуулийн хэрэгжилт аудитаар үлдсэн 22.9 сая төгрөгийн төлбөрийн актаас Жаргалант сумын газрын даамал болон бусад харилцагч талуудтай хамтран 13.9 сая төгрөгийг бүрэн барагдуулж, нэг аж ахуйн нэгжийн 9.0 сая төгрөгийн үлдэгдлийг график гаргаж төлж барагдуулахаар шийдвэрлэлээ.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан

Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудит



Орхон аймгийн Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн Орхон аймгийн 2024 оны төсвийн төсөлд аудит хийж, тайланг 12 дугаар сарын 01-ний өдрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанд танилцуулсан. Аудитын тайлан, дүгнэлтээр аймгийн ИТХ-д 1 зөвлөмж, Засаг даргад 2 зөвлөмжийг хүргүүлсэн. Аудитаар төсвийн төсөлд 709.0 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх, 3,463.9 сая төгрөгийн зардал бууруулах саналыг хүргүүлснээс ИТХ-аар төсвийн орлогыг 400.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн тул үр өгөөжөөр хүлээн зөвшөөрүүллээ.

ТАВДУГААР БҮЛЭГ. ИТХ-ЫН ХҮСЭЛТЭЭР БОЛОН ӨӨРСДИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТ

“Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг 2023 оны 05 сарын 22-нд баталж, аудитын нээлтийг 2023 оны 05 сарын 30-ны өдөр зохион байгуулсан.



Оны 11 дүгээр сарын 24-ны өдөр Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.

Орхон аймгийн Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн Орхон аймгийн 2024 оны төсвийн төсөлд аудит хийж, тайланг 12 дугаар сарын 01-ний өдрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанд танилцуулсан. Аудитын тайлан, дүгнэлтээр аймгийн ИТХ-д 1 зөвлөмж, Засаг даргад 2 зөвлөмжийг хүргүүлсэн. Аудитаар төсвийн төсөлд 709.0 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх, 3,463.9 сая төгрөгийн зардал бууруулах саналыг хүргүүлснээс ИТХ-аар төсвийн орлогыг 400.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн тул үр өгөөжөөр хүлээн зөвшөөрүүллээ.

Аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэж, аудитын тайланг 2023 оны 09 сарын 29-ны өдрийн A/14 дүгээр тушаалаар баталгаажуулан, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т хүргүүлсэн. Аудитаар нийт 34,878.8 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлж, дотоод хяналтыг сайжруулж, мэдээллийн ил тод байдлыг хангах талаар 3 зөвлөмж хүргүүлсэн.

МУЕА-ын 2022 оны A/94 дүгээр тушаалаар баталсан “Аудитын зөвлөлийн ажиллах журам”-ын дагуу “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн аудитын тайлан аудитын зөвлөлийн хуралдаанаар 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөр танилцуулсан. Аудитын зөвлөлийн хурлаар өгсөн чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийн хяналтын хуудсыг 2023



ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ДОТООД АЖИЛ

Сургалт

Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөг албан хаагчдаас сургалтын хэрэгцээ шаардлагын судалгаа авч, тулгамдаж буй ахиц дэвшил шаардсан болон өмнөх оны аудитын чанарын хяналт хийх явцад гарсан анхаарах асуудлуудыг үндэслэн 2023 онд хэрэгжүүлэх сургалтын сэдвийг боловсруулж, дотоод сургалтын төлөвлөгөө” баталсан.

Сургалтын төлөвлөгөө хууль, эрх зүй, журам заавар, бусад чиглэлээр 20 төрлийн 46.5 цагийн сургалтад давхардсан тоогоор 240 албан хаагч хамруулахаар төлөвлөсөн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн ханггуулж, нийт 28 сургалтад давхардсан тоогоор 308 албан хаагч хамрагдсан.

	ҮАГ-аас зохион байгуулсан	Дотоод сургалт	Бусад сургалт
Онлайн	2/22		1/66
Цахим	32/192		
Танхим	2/4	26/286	14/83
Хосолсон		2/22	

Дотоод сургалт:

Байгууллагын дотоод сургалтын нөлөөгөөр албан хаагчид харилцан туршлага солилцон, мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн.

2023 оны санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн завсрлын аудитын талбарын ажлыг гүйцэтгэхдээ албан хаагчид бие биедээ харилцан туслах замаар биеэсээ суралцан, сайн туршлагаа хуваалцах боломжийг бүрдүүлсэн. Ингэхдээ 7 хоног бүр өөр өөр албан хаагчидтай талбарын ажлыг гүйцэтгэж, өөрийн болон хамт явсан албан хаагчийнхаа хуваарыт байгууллага дээр очиж ажилласан. Завсрлын аудитыг гүйцэтгэж дууссаны дараа албан хаагчдаас санал асуулга авах замаар хамгийн сайн хамтрагчдаа тусалж, сайн туршлагаа хуваалцсан албан хаагчийг шалгаруулсан.

Төрийн аудитын байгууллагад мөрдөж буй журам, заавар, аргачлалын тодорхой сэдвийг албан хаагч судалж, сургалтын материал бэлтгэн, хичээл зааснаар албан хаагчдын мэдлэг тэлж, хөгжихөд таатайгаар нөлөөлсөн.





Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан



Онцгой байдлын байгууллагаас “Гамшиг ба бэлэн байдал”, Насан туршийн суралцахуйн төвөөс “Багаар ажиллах чадвар”, “Хүүхдийн сэтгэл гутрал”, “Ажлаа зохион байгуулах, ажлын цаг ашиглалт, бүтээлч байдал”, “Хэрэглээний программ”, “Англи хэл-ярих, сонсох чадвар” сэдвээр сургалт авч, хөгжих боломжийг бүрдүүллээ.



Албан хаагчдыг чадавхжуулах ажлын хүрээнд 2023 оны 11 сарын 02-оос 03-ны өдрүүдэд ҮАГ-ын СНАГ, ГНАГ-ын өдөр тутмын үйл ажиллагаатай танилцаж, “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих” төсөлтэй хамтран зохион байгуулсан аудиторуудыг чадавхжуулах сургалт-семинарт нийт албан албан хаагчид хамрагдсан.

Хянан удирдах албан тушаалтнуудаас чанарын хяналтаа хэрхэн хэрэгжүүлдэг талаар аргазүйн зөвлөгөө авч, туршлага судалсан. СНАГ-ын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, аудитын менежерүүдийн сайн туршлагаас суралцсан.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан



ҮАГ-аас зохион байгуулсан сургалт:

ТАБ-ын хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулсан сургалтуудад тухай бүр оролцон, өгсөн чиглэл арга зүйг хэрэгжүүлж, ҮАГ-аас зохион байгуулсан 36 сургалт, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 218 албан хаагч хамрагдлаа.

Тайлант онд ТАБ-ын сургалтын цахим системийн төлөвлөгөөт сургалтад 10 албан хаагч, 21 хичээлд хамрагдсанаас 13 нь сертификат авч, 6 сургалт дуусаагүй үргэлжилж, 2 сертификат аваагүй байна.

ҮАГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж болох ГНАГ-ын зохион байгуулсан 5, СНАГ-ын 6, МТТ-ийн 5, АНУЗГ-ын 1, ЗХЭЗГ-ын 3, ХБТГ-ын 16 сургалт, хэлэлцүүлэгт албан хаагчид бүрэн хамрагдсан.

“Excel, Dashboard, Power Bi, Дата анализ болон Data science”-ийн системийн сургалт, “Typing Study” программ арван хуруугаар бичиж сурах онлайн сургалтад бүх албан хаагч бүрэн хамрагдлаа.

Бусад сургалт:

Аймгийн хэмжээнд зохион байгуулсан 15 удаагийн сургалтад давхардсан тоогоор 149 албан хаагч тус тус хамрагдлаа.

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, түүний эхний үе шат “Шинэ сэргэлтийн бодлого”-ын богино хугацааны сургалтад 11 албан хаагч хамрагдаж, сертификат авч, амжилттай суралцсан.
- Монгол Улсын хууль эрх зүйн шинэчлэлийн 6, мэдлэг боловсрол дээшлүүлэх 3 сургалт, хэлэлцүүлэгт нийт 58 албан хаагч хамрагдсан.
- Газар хөдлөлтийн гамшиг тохиолдож “онц байдал” тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа сургуулийн мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд 1 албан хаагч ажилласан.
- Төрийн албаны зөвлөл, Орхон аймгийн Засаг дарга, ЗГХЭГ, УИХ-ын Тамгын газраас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй-Гүйцэтгэлийн удирдлага” сэдэвт чадавхжуулах сургалтад дарга, тэргүүлэх аудитор, ахлах аудитор хамрагдсан.
- ТАЗ-ийн “7:4:10” цахим сургалтад 7 хоногийн Пүрэв гариг бүр “Төрийн албан хаагч ба дипломат ёслол”, “Аз жаргалтай ажилтан”, “Аз жаргалтай ажлын байр:Стресс менежмент”, “Амжилтад хүрэх хүсэл”, “Шинэ зууны манлайллын хэв маягууд”, “Монгол Улсын тусгаар тогтнол ба Богд хаан” зэрэг сургалтуудад хөтөлбөрийн дагуу бүх албан хаагчид хамрагдлаа.



Албан харилцаа

Эйбл программын тусламжтайгаар албаны харилцаа, холбоо түргэн шуурхай, найдвартай системээр явагдаж байна. Тус программын захидал, ажил хэрэг, албан бичиг, цаг бүртгэл, олон нийтийн цэсүүдийг өдөр тутамдаа тогтмол хэрэглэж хэвшсэн.

Мөн цахим шуудан, санхүүгийн тайлангийн FAS систем, TEAMS, ZOOM, surgalt.audit.mn цахим системүүдийг ашиглан аудит, сургалт, уулзалт, хурал зөвлөгөөнүүд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран амжилттай зохион байгуулагдаж, бидний өдөр тутмын харилцаа холбооны хэрэгсэл болсон байна.

Байгууллагын үйл ажиллагааны талаарх товч тайлан болон аудитын явцын мэдээллийг 14 хоног тутам 3ХЭЗГ, www.data.audit.mn цахим системд мэдээлж ажиллалаа.

Авлигын эсрэг үйл ажиллагаа

2023 оны 01 сарын 28-ны өдрийн А/02 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө"-г 5 зорилт, 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан. 2022 оны ХАСХОМ мэдүүлэх 10 албан хаагчаас 10 албан хаагч мэдүүлж, баталгааны хуудсыг хүлээн авч баталгаажуулсан. Байгууллагын ХАСХОМ-ийн тайланг 2023 оны 02 дугаар сарын 19-нд баталгаажуулж, УАГ-ын ЭБАТ-д хүргүүллээ. Санхүүгийн тайлангийн аудитаар 122 төсвийн шууд захирагч, 1 төвлөрүүлэн захирагч, 1 ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн өмчтэй 11 аж ахуйн нэгжийн удирдлага, нягтлан бодогч нарт "Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам"-ын 2 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу нөлөөллийн мэдүүлгийн талаар танилцуулсан баримтыг хөтөлсөн. Албан хаагчид Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрмийг даган мөрдөж, хувийн ашиг сонирхлоос ангид байж, хуулийн хүрээнд албан үүргээ биелүүлэн ажиллаж байна.

"Авлигын эсрэг НЭГДҮЕ" постерыг байгууллагын нийгмийн сүлжээний ковер зургаар байршуулж, тус аянд нэгдэж буйгаа илэрхийлж бэлтгэсэн зургуудыг байгууллагын Фэйсбууц профайл болон пэйж хуудаст байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн. АТГ-аас өрнүүлж буй аяныг дэмжин ажиллаа.

Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан "Төрийн байгууллагын удирдах ажилтнуудын авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг дээшлүүлэх, төрийн албаны болон төсвийн хуулийн хэрэгжилтийг хангах, удирдах ажилтны манлайллыг нэмэгдүүлэх уулзалт, хэлэлцүүлэг"-т ЭБАТ хариуцсан албан хаагч хамрагдсан.

"Төрийн албаны тухай хууль, хуулийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал", "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсээс 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр сургалт авч, албан хаагчид бүрэн хамрагдсан.

АТГ-аас бэлтгэсэн НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн болон Залуучуудаа авлигын эсрэг аянд нэгдэцгээе видео мэдээлэл, Товш аппликэйшн танилцуулга, Авлигыг мэдээлэх системийг сайжруулах нь судалгаа



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан

зэрэг мэдээллийг Фэйсбууک профайл болон пэйж хуудаст байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн.

Төрийн албаны зөвлөл, Орхон аймгийн Засаг дарга, ЗГХЭГ, УИХ-ын Тамгын газраас зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй-Гүйцэтгэлийн удирдлага" сэдэвт чадавхжуулах сургалтад дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах, ахлах аудитор В.Жавзмаа нар 2023 оны 10 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд хамрагдаж, сургалтын агуулгаар нийт албан хаагчдад мэдээлэл өгсөн.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны сургалтын төлөвлөгөөний хүрээнд "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ТАБ-ын албан хаагчийн мөрдөх ёс зүйн дүрэм"-ээр ахлах аудитор В.Жавзмаа 2023 оны 10 сарын 04-ны өдөр байгууллагын нийт албан хаагчдад дотоод сургалт зохион байгууллаа.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөний хүрээнд шалгагдагч этгээд, аудитад хамрагдагч байгууллага, албан хаагчдаас ТАБ-ын ажилтнууд авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйн асуудал гаргасан эсэх талаар цахим санал асуулга авч, үнэлгээ хийсэн. Санал асуулгын үр дүнгээр хамгийн их хөндөгдсөн сөрөг сэтгэгдэл нь албан хаагчдын харилцаа, хандлагын асуудал байсан тул байгууллагын шуурхай хуралдаанаар нийт албан хаагчдад харилцаа, хандлага, үг үйлдэлдээ анхаарч, хүний эрхийн мэдрэмжтэй ажиллах талаар чиглэл, заавар өгсөн.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг албан хаагчдын анхааралд тод хүргэх, бүрэн таниулах үүднээс "Эрдэнэс легал консалтинг" хуулийн фирмийн хуульч, өмгөөлөгч Э.Түмэнбаяраас "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль"-аар 2023 оны 10 сарын 24-ний өдөр сургалт авсан.

Мэдээлэл, технологи

Тайлант онд гүйцэтгэсэн санхүүгийн аудитын 100, гүйцэтгэлийн аудитын 5 тайланг tailan.audit.mn, open.audit.mn цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлсэн.

Байгууллагын фэйсбууک профайл нээж 5000 найзтай, пэйж нээж 940 дагагчтай болж, нээлттэй мэдээлэл, тайлан, ЯАГ-ын пэйж хуудаст байршуулсан визуал, инфографик тайлан, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг нийтлэл, видео хэлбэрээр иргэд, олон нийтэд түгээн, сурталчиллаа.

Байгууллагын 2022, 2023 онд хэрэгжүүлсэн олон нийтэд чиглэсэн арга хэмжээнүүдээр видео бэлтгэж байгууллагын цахим хуудсанд байршуулж иргэд, олон нийтэд хүргэлээ.

Дотоод удирдлагын Эйбл систем, Zoom, Teams, Эрдэнэт И-Оффис зэрэг программуудыг ашиглан мэдээлэл, дата, файлыг шуурхай хүлээн авч, газар дотроо болон ТАБ-ын хэмжээнд харилцан солилцож, ЯАГ болон МТТ-өөс зохион байгуулсан хэлэлцүүлэг, хурал, семинар, сургалтуудад тухай бүр холбогдох албан хаагчид хамрагдаж, ирүүлсэн чиглэл, зааварчилгаа, санал асуулгыг шуурхай дамжуулж, хэрэгжүүлэн ажиллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын FAS цахим системийн сургалтад тухай бүр хамрагдан, ашиглалт хөгжүүлэлт, заавар чиглэлийг хэрэгжүүллээ.



Архив, албан хэрэг хөтлөлт

Байгууллагын дотоод үйл ажиллагаанд ABLE системийг тогтмол ашиглаж хэвшилээ.

Байгууллагын төлөвлөсөн албан бичиг, акт, албан шаардлагын утга найруулга болон хууль, эрх зүйн үндэслэлтэй боловсруулсан эсэхэд хяналт тавьж, аудит болон үйл ажиллагаанд тулгамдсан асуудлаар ҮАГ-аас заавар, зөвлөмж авч ажилласан. 2023 оны 12 сарын 01-ны байдлаар явсан бичиг 238, А тушаал 15, Б тушаал 7, төлбөрийн акт 147, албан шаардлага 137, аудитын дүгнэлт 103 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу боловсруулан, холбогдох байгууллагад хүргүүлсэн. Төсвийн тухай хуулийн дагуу санхүүгийн тайланда аудит хийлгэх хүсэлт 136, ҮАГ-аас 41, санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 109, бусад 21, нийт 307 бичиг ирснийг 100 хувь хугацаанд нь хянан шийдвэрлэсэн. Байгууллагын 2023 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг ББНШК-ийн хурлаар хэлэлцэн баталж, албан бичгийн бүртгэлийн цахим санг үүсгэн, албан бичгүүдийн шийдвэрлэлтэд бүртгэлээр хяналт тавьж, хариуг хугацаанд нь өгч ажилласан. 2023 онд байгууллагын архивд байнга хадгалах 142, түр хадгалах 33, 70 жил хадгалах 2 баримтыг стандартын дагуу товьёг, баталгааны хуудсаар баталгаажуулан, хүлээн авч бүртгэл хөтөлсөн. Мөн ББНШК хуралдаж түр хадгалах хадгаламжийн нэгжийн устгах баримтын жагсаалтын аймгийн Архивын тасгийн БНШАЗК-д 2023 оны 10 сарын 25 өдрийн 233 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан.

Үүрэг даалгаврын хэрэгжилт

2023 оны 11 сарын 27-ны байдлаар МУЕА-н тушаалаар өгөгдсөн 25 үүрэг даалгаврыг заалт нэг бүрээр бүрэн хэрэгжүүлж, хэрэгжилтийн тайланг улирал бүр өссөн дүнгээр ЗХЭЗГ-т nomindarim@audit.gov.mn хаягаар хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий аудиторын А тушаалаа /2022 оны 4, 2023 оны 21/ өгөгдсөн үүрэг чиглэлийн хүрээнд 25 заалтыг хяналтад авч, биелэлтийг 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар гаргаж Захиргаа хууль, эрх зүйн газарт nomindarim@audit.gov.mn цахим хаягаар 2023 оны 11 дүгээр сарын 27-нд хүргүүлсэн. Тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжилтийн хугацаанд бүрэн хангаж ажилласан.

Төрийн аудитын байгууллагын 2023 оны удирдах ажилтны нэгдсэн сургалт, семинараас АНТАГ-уудад 7 үүрэг даалгавар өгсөн.

Зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавруудыг хэрэгжүүлэн ажиллаж, хэрэгжилтийн тайланг Захиргаа хууль, эрх зүйн газарт nomindarim@audit.gov.mn цахим хаягаар улирал бүр заасан хугацаанд хүргүүлсэн.

Шинэ санаачилга

Орхон аймаг дахь Төрийн аудитын газар иргэд олон нийт, нийгэмд чиглэсэн болон сайн үйлсийн аяныг амжилттай хэрэгжүүллээ.

Орхон аймгийн Биеийн тамир, спортын газрын ахлах мэргэжилтэн Д.Одгэрэлийн хандивын аянд нэгдэж, БТСГ-аас зохион байгуулсан спортын арга хэмжээнд оролцож, мөнгөн хандив өргөлөө.

Мөн элэгний хүнд өвчтэй Бүгд найрамдах Энэтхэг улсад эмчилгээнд явах иргэнд сэтгэлийн хандив, тусlamж өгсөн.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан



Орхон аймгийн Биеийн тамир, спортын газартай 2023 оны 05 сарын 11-ний өдөр спортын 5 төрлөөр нөхөрсөг тэмцээн зохион байгуулж, шилжин явах цомын эзэн болсон.




Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 63 дугаар зарлигаар жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гаригийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” болгон зарласан билээ. Энэхүү өдрийг тохиолдуулан 2023 оны 05 болон 10 дугаар саруудад хамт олноороо мод тарьсан.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын хамт олон Баян-Өндөр уулын чиглэлд 2023 оны 06 сар болон 11 саруудад алхалт хийж, 10 га орчим талбайд тархсан хог хаягдлыг түүж цэвэрлэлээ. Мөн цас орох бүрд байгууллагын гаднах зам, талбайн цасыг тогтмол цэвэрлэж хэвшсэн.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан



Монгол Улсад санхүүгийн алба үүсэж хөгжсөний 112 жилийн ойн баярын хүрээнд 2023 оны 11 сарын 30-ны өдөр зохион байгуулагдсан “Санхүүчид дуулж байна” тэмцээнд хоёрдугаар байр эзэллээ.



Монгол Улсад санхүүгийн алба үүсэж хөгжсөний 112 жилийн ойн баярын хүрээнд 2023 оны 12 сарын 02-оос 2023 оны 12 сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Тамирчин санхүүч-2023” спортын наадамд оролцож, гарбэмбөг, дартс, ширээний тениссийн төрөлд тус тус хоёрдугаар байр эзэллээ.



Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн Санхүү, менежментийн тэнхимийн ахлах багш, Эдийн засгийн ухааны доктор (Ph.D) Т.Элдэв-Очирын судалгаа, шинжилгээний ажлуудтай танилцаж, тус сургуулийн багш нарын судалгаа, шинжилгээний ажлуудыг холбогдо аудитад ашиглах талаар санал солилцлоо. Мөн байгууллагынхаа үйл ажиллагааг Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн оюутан, залууст танилцуулж, “байгууллагын эрсдэлийн үнэлгээ” сэдвээр сургалт зохион байгууллаа.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан

ДОЛООДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны төсвийн сар, улирлын хуваарийг МҮЕА-оор батлуулж, хуваарийн дагуу тайлант жилд 518.0 сая төгрөгийн санхүүжилт авснаас цалин хөлс нэмэгдэл хоол унааны зардалд 419.0 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 52.7 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 0.4 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 5.7 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 4.0 сая төгрөг, томилолтын зардалд 0.3 сая төгрөг, урсгал засварын зардалд 4.0 сая төгрөг, томилолт зочны зардалд 0.3 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 0.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 0.5 сая төгрөг, бусад урсгал шилжүүлэг 0.7 сая төгрөг нийт 483.9 сая төгрөг зарцуулсан. Эдийн засгийн ангилал тус бүрээр хэтрэлтгүй, батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг бүрэн хангаж ажиллаа.

2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын цалин хөлс шинэчлэн тогтоосонтой холбоотой төсөвт тодоттол орсон бусад зардлыг бууруулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, ЗГ-ын тогтоолыг мөрдөн, өр авлага үүсгэхгүй ажиллалаа. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр, ҮАГ-аас ирүүлсэн мэдээ, судалгааг цаг тухай бүр гаргаж, ҮАГ-ын ЗХЭЗГ-т хүргүүлж ажилласан.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд "Мишээл од аудит" ХХК-аар баталгаажуулах аудит хийлгэж, "зөрчилгүй" санал дүгнэлт авсан аудитаар 1 зөвлөмж авч зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 28-ны 192 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Байгууллагын 2024 оны төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж, тооцоо судалгааны хамт ҮАГ-т 2023 оны 06 дугаар сард хүргүүлсэн.

Байгууллагын шилэн дансны мэдээллийг хууль журмын дагуу shilendans.gov.mn цахим хуудсанд тухай бүр оруулах 99 мэдээлэл, сар бүр оруулах 40 мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 1 мэдээлэл, байгууллагын батлагдсан төсөв 1 мэдээлэл, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт 1 мэдээлэл, батлагдсан төсөв 1 мэдээлэл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан 1 мэдээлэл нийт оруулах ёстой 148 мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулсан.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан

НАЙМДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Дүгнэлт

- Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах зорилтын хүрээнд 2023 онд гүйцэтгэсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн биелэлт, үр дүнгийн талаар Erdenet.mn сайт, байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлж, орон нутгийн телевизэд 4 удаа ярилцлага өгсөн. Хугацаа хэтэрсэн аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй судалгаа гаргаж, хэрэгжээгүй шалтгаан нөхцөлийг тодруулан, хэрэгжилтийг хангуулах олон талт арга хэмжээ авч ажиллаа. Аудитын үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах ажлын хүрээнд Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлыг улирал бүр зохион байгуулж хэвшсэн.
- Албан хаагчид бие биеэсээ суралцан, сайн туршлагаа хуваалцах замаар мэргэжлийн үр чадвараа нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн.
- Санхүүгийн тайлангийн аудитыг FAS цахим системээр гүйцэтгэн, санал зөвлөмж, залруулах асуудлыг цахимаар өгч ажиллаа.
- Иргэд олон нийт, нийгэмд чиглэсэн болон сайн үйлсийн аяныг амжилттай хэрэгжүүллээ.
- МҮЕА-н тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүллээ.
- Байгууллагын 2023 оны Мэргэжлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөөг бүрэн хангалттай хэрэгжүүллээ.

Санал

- Гадаад сургалт, элчин сайд, консулын газрын аудитад албан хаагчдаас хамруулах

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:


/Б.БУЯН-УНДРАХ/

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:


/Ц.НАРМАНДАХ/

